



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

ИТГЭЛЦЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ БИЙ БОЛГОХ НЬ

ЗАМЫН ЗУРАГЛАЛ 2026

Монгол дахь Америкийн
Худалдааны Танхим

ОРШИЛ

2026 он тогтворгүй байдлыг боломжтой хослуулсан онцгой жил болох төлөвтэй байна. Монгол Улс дотооддоо сонгуулийн дараах нөхцөл байдлыг туулж байгаа бөгөөд олон нийтийн бухимдал нь авлига, өндөр инфляц, тэгш бус байдалд төвлөрч байна. Засгийн газраас авлигатай тэмцэх болон цахим засаглалын шинэчлэл өрнүүлж буй нь Монгол дахь Америкийн Худалдааны Танхимын (АмЧам) олон жилийн турш дэвшүүлсэн ил тод байдлыг урагшлуулах боломж юм.

Эдийн засгийн хувьд уул уурхайгаас шалтгаалсан 5.7%-ийн өсөлттэй байх төлөвтэй ч инфляц өндөр буюу 7.2%, БНХАУ-ын эрэлт буурч байгаа нь эрсдэл хэвээр байна. Зудын аюултай нөлөө нь сүүлийн жилүүдэд уул уурхайн бус салбарын эмзэг байдлыг эргэн санууллаа. Үүний зэрэгцээ АНУ-ын Төрийн Департамент гаргасан Монгол Улсын 2025 оны хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэлд маргаан шийдвэрлэх үйл ажиллагааны үр дүнгүй байдал, хөрөнгө албадан хураах эрсдэл дагуулахуйц шинэ хуулиуд, жишээлбэл 2024 оны стратегийн ордтой холбоотой хуулийн өөрчлөлтүүдийн талаар болгоомжлуулсан билээ.

Бүс нутагт АНУ болон Монгол Улсын "Гуравдагч хөршийн" түншлэл түүхэндээ хамгийн бат бөх түвшинд хүрээд байна. АНУ нь стратегийн нийлүүлэлтийн сүлжээг (критикал минерал, цэвэр эрчим хүч) нөхөрсөг орнуудад төвлөрүүлэх бодлого баримталж буй ч Монгол Улс дэлхийн худалдааны гол коридоруудтай холбогдох дэд бүтцийг хангалттай хөгжүүлээгүй хэвээр байна.

Дотоодод бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчид эрх зүйн орчин, зохицуулалтын тогтворгүй байдал, хууль хэрэгжилтийн субъектив хандлагатай тулгарсаар байна. Шалгалт, мөрдөн шалгах ажиллагаа, маргаан шийдвэрлүүлэх явцад тодорхой хууль эрх зүйн зохицуулалтын арга замууд, хугацааны цар хүрээ байхгүй зэрэг нь бизнесийн итгэлцэл, хөрөнгө оруулалтад ноцтой хохирол учруулсаар байгаа билээ.

Цаашлаад хууль хяналтын байгууллагыг улс төрийн зорилгоор ашиглах оролдлого нэмэгдэж байгааг бизнесүүд мэдээлж буй нь хувийн хэвшлийн эсрэг улс төрийн шинж чанартай үйлдлүүд нэмэгдсэн, мөн Монголын нэр хүндийг сэвтээж байгаа дохио юм. Итгэлцлийг сэргээх эрх зүйн болон бодлогын шинэчлэл нэн шаардлагатай болсон байна.

2026 оны бидний стратеги болох "Итгэлцлийн эдийн засаг" нь эдгээр сорилтыг үр дүнтэй даван туулахад чиглэгдсэн. Бид АмЧамын гишүүдийг Монголын итгэлцэл алдагдсан байдалд шийдэл нь болж, гуравдагч хөршийн бодлогын хэрэгжилтийг дэмжих гол түнш байж чадна гэдэгт итгэл төгс байна.

2026 оны бодлогын тэргүүлэх чиглэлүүд

1. Шударга, тогтвортой, ил тод систем тогтоох
2. Түншлэл ба төрөлжилтөөр эдийн засгийн дархлааг бэхжүүлэх
3. Хувийн хэвшлийг итгэлцлийн загвар болгон төлөвшүүлэх

ШУДАРГА, ТОГТВОРТОЙ, ИЛ ТОД СИСТЕМ ТОГТООХ

Бид хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог сайжруулах, хөрөнгө оруулалтыг үргээдэг улс төрийн болон эрх зүйн эрсдэлүүдийг арилгах, бизнесийн итгэлцлийг сэргээх болон хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах чиглэлээр бодлогын ажлуудыг хийж гүйцэтгэх болно.

А. Ил тод байдал ба хариуцлагыг нэмэгдүүлэх

Цахим шийдлүүд ашиглан олон нийтэд нээлттэй тайлагнах зарчмаар засаглалын стандартыг мөрдүүлэх, авлигыг бууруулах тухайд:

- АмЧамын Хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ: Салбарууд болон яамдыг ил тод байдал, маргаан шийдвэрлэлт, зохицуулалтын дарамтын түвшнээр нь үнэлэх дата суурьтай хэрэгсэл байх
- Цахим засаглалыг хяналтын хэрэгсэл болгох: Засгийн газрын худалдан авалт, төсвийн зарцуулалт, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хэлбэрээр И-Монгол цахим үйлчилгээний систем болон бусад цахим системээр дамжуулан ил болгохыг дэмжих
- Техникийн туслалцаа ба чадавх бэхжүүлэх: Иргэний нийгэм, хараат бус хэвлэл мэдээлэлд цахим дата мэдээлэлд дүн шинжилгээ, мониторинг хийх, мэдээлэх чадавх бий болгох замаар үр дүнгүй зарцуулалт, авлигын эрсдэл зэргийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Б. Хөрөнгө оруулалтын голлох эрсдэлийг бууруулах

Хөрөнгө оруулагчдын итгэлийг хамгийн их доройтуулж буй эрх зүйн болон зохицуулалтын эрсдэлүүдэд тохирсон зорилтот шинэчлэл шаардлагатай тухайд:

- Хөрөнгө оруулагчдын бодит кейсүүдэд суурилан хууль эрх зүй, зохицуулалтын тодорхой арга замууд шаарддаг болох: Маргаан дагуулсан кейсүүдийг нэгтгэн танилцуулж, шалгалт, мөрдөн шалгах ажиллагаа, маргаан шийдвэрлэлтийн явц заавал тодорхой хугацаатай, тодорхой дүрэм журамтай байхыг хуульчилсан шинэчлэл шаардах
- Хөрөнгө хураах эрсдэлийг хянах: Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд Ашигт малтмалын тухай хуулийн заалтыг өөрчлөн найруулсан үр дагаварт дүн шинжилгээ хийж, стратегийн ордод хамааруулан хөрөнгө хураах эрсдэл байхгүй талаарх баталгаа өгөхийг Засгийн газраас хүсэх
- Татварын маргааныг шийдвэрлэх: Хараат бус арбитрын байгууллага бий болгохыг дэмжиж, үндэслэлгүй бөгөөд хэтийдсэн татварын акт үйлдэх зөрчлийг зогсооход хувь нэмэр оруулах.

ТҮНШЛЭЛ БА ТӨРӨЛЖИЛТӨӨР ЭДИЙН ЗАСГИЙН ДАРХЛААГ БЭХЖҮҮЛЭХ

Олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд Монголын стратегийн холболт болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, гуравдагч хөршүүдийн өндөр стандартыг хангасан нийлүүлэлтийн сүлжээтэй уялдуулахад дэмжиж ажиллах бөгөөд ингэхдээ АНУ-ын стратегийн нийлүүлэлтийн сүлжээг нөхөрсөг орнуудад төвлөрүүлэх бодлогыг баримтална.

А. Хэрэгжиж буй хоёр талт гэрээ, хэлэлцээрүүдийг хөрөнгө оруулалт, худалдаанд ашиглах

АНУ-Монгол Улс хоорондын дараах гэрээнүүдийн хамгаалалт, давуу тал, боломжийн талаар хөрөнгө оруулагчдад идэвхтэй сурталчлан таниулах:

1

Хоёр талт хөрөнгө
оруулалтын гэрээ
(BIT, 1997)

2

Худалдаа, хөрөнгө
оруулалтын ерөнхий
хэлэлцээр (TIFA, 2004)

3

Ил тод байдлын гэрээ
(2017)

4

Нээлттэй тэнгэрийн гэрээ
(2023)

Б. Цахим болон агаарын коридорыг хөгжүүлэх

Шууд нислэгийн эдийн засгийн өгөөж тогтвортой байхад дэмжиж ажиллах, мөн Монгол Улсын цахим дэд бүтцийн хөгжилд АНУ-ын технологи, стандарт ашиглахыг уриалах, улмаар цахим коридорыг хөгжүүлж худалдаа, аюулгүй байдал, ардчилалд суурилсан засаглалыг бэхжүүлэх юм.

В. Эрчим хүчний шилжилтийг дэмжих

Сэргээгдэх болон уламжлалт эх үүсвэрийн аль алийг нь багтаах туршлагыг дэмжиж, эрчим хүчний реформыг түүчээлэн ажиллана. Ингэснээр АНУ-ын санхүүжилт, технологи, төслийн хэрэгжилтийг Монголын эрчим хүчний хараат бус байдал болон бүсийн эрчим хүчний экспортын чадавхтай уялдуулах боломжтой юм.

Г. Стратегийн ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээг баталгаажуулах

Өндөр технологийн түүхий эд буюу критикал минералын хайгуул, олборлолт, экспортыг дэмжих зорилгоор АНУ-ын хөрөнгө оруулалт, технологи ашиглалтыг нэмэгдүүлэх тусгайлсан ажлын хэсэг байгуулна. Ингэхдээ АНУ-ын стратегийн нийлүүлэлтийн сүлжээг нөхөрсөг орнуудад төвлөрүүлэх бодлогыг баримтална.

Д. Бизнес болон хөрөнгө оруулагчдыг холбох

АНУ-Монгол Улсын бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх тусгайлсан ажлын хэсэг байгуулах тухайд:

- АНУ-ын Худалдааны танхим болон АНУ-ын Худалдааны яамны хүрээлэлд тулгуурлан зорилтот хөрөнгө оруулагчдад хүрч, хөрөнгө оруулалтын боломжуудыг таниулах
- Монгол болон АНУ-ын компаниудын харилцан ашигтай түншлэлийг дэмжих
- АНУ-Монгол Улсын худалдааны өндөр түвшний айлчлалыг зохион байгуулж, хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг өргөжүүлэх.



ХУВИЙН ХЭВШЛИЙГ ИТГЭЛЦЛИЙН ЗАГВАР БОЛГОН ТӨЛӨВШҮҮЛЭХ

Хувийн хэвшлийг хамгийн найдвартай, тогтвортой өсөлтийн хөдөлгүүр гэдгийг, харин АмЧамын гишүүн байгууллагуудыг ёс зүйтэй, итгэл даахуйц гэдгийг олон нийтэд таниулна.

А. "Итгэлцлийн эдийн засаг" олон нийтийн кампанит ажил хэрэгжүүлэх

Дата мэдээлэл дээр суурилсан кампанит ажлаар хувийн хэвшлийг төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй харьцуулан ажлын байр бий болгосон байдал, инновац, ёс зүй зэргээр үнэлж харуулна.

Б. Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ) болон Компаенсийн стандартын хэрэгжилтийг дэмжих

Жил бүр гишүүн байгууллагуудынхаа нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлыг дүгнэн, шалгаруулалт зохион байгуулж, шагнал олгогдгийг "Бизнесийн итгэлцлийн шагнал" болгон шинэчилж, олон улсын БОНЗ, (FCPA г.м.) авлигын эсрэг стандарт, компанийн сайн засаглалыг хангадаг гишүүн байгууллагуудыг сурталчлан таниулдаг болно.

В. Компанийн засаглал ба ТУЗ-ийн чадавхыг бэхжүүлэх

АмЧамыг Монголын хувийн хэвшил дэх засаглалын шилдэг туршлагыг түгээх хөдөлгөгч хүч болгоно. Компаниудад орчин үеийн, хариуцлагатай ТУЗ-ийн бүтэц бий болгох, одоо ажиллаж буй болон дараагийн үеийн ТУЗ-ийн гишүүдийг байгууллагуудаас шаарддаг мэдлэг, ур чадвар, ёс зүйн суурь ойлголтоор хангахад санаачилгатай ажиллана. Үүнд ТУЗ-ийн бэлэн байдлын хөтөлбөр боловсруулах, засаглалын мастер класс зохион байгуулах, мөн өндөр хөгжилтэй улсуудын амжилттай загварыг ашиглан ирээдүйн магадлан итгэмжлэлийн боломжуудыг судлах зэрэг нь багтаж болно. Удирдлагуудад тэдний итгэмжлэлийн үүрэг, хариуцлага, хил хязгаарыг ойлгуулах замаар АмЧам илүү нээлттэй, тогтвортой, олон улсад үнэлэгдсэн бизнесийн орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах болно.